



ХААН СОЁМБО АУДИТ ХХК

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2023/21/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:
www.audit.mn

Хөвсгөл аймаг
2022 он

Аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99069114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichko.0608@gmail.com

Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал: Х.Диймаа
Утас: 99065668 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Хаан соёмбо аудит ХХК-ийн аудитор: Н.Бадамханд
Утас: 99042699 Цахим хаяг: info@khaansoyomboaudit.mn

Энэхүү аудитын тайлантай хөлбостой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
3. Аудитын тайлан	9
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	9
3.2 Байгууллагын гадаад дотоод орчин	9
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	10
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	12
4.1 Ерөнхий зүйл	12
4.2 Материаллаг байдал	12
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	12
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	13
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. Аудитын илрүүлэлт	14
5.2 Төлбөрийн акт	14
5.3 Албан шаардлага	14
5.4 Зөвлөмж.....	14
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	14

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮЯ	Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

таныг Хөвсгөл аймаг № 01/84
-ны № _____ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХҮНС ХӨДӨӨ АЖ
АХУЙН ГАЗРЫН ДАРГА Я.ЭРХЭМБАЯР
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Эзэмших эрхтэй 5,100.0 м.кв хэмжээтэй 102,520.0 мянган төгрөгийн газрыг бүртгэж дүрмийн сангаа нэмэгдүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Төсвийн хөрөнгөөр 447.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл бэлдэж Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллаагүй зөрчил илэрлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 49 арга хэмжээ 91 хувийн үнэлгээтэй дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



А.ЭРДЭНЗБААТАР

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	164,227,569.69	156,905,200.59
33	АВЛАГА	19,057,964.00	19,057,964.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	15,025,964.00	15,025,964.00
335	Бусад авлага	4,032,000.00	4,032,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,032,000.00	4,032,000.00
34	УРЬДЧИЛГАА	7,200,000.00	00.00
34600	Урьдчилж гарсан зардал	7,200,000.00	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	137,969,605.69	137,847,236.59
354	Хангамжийн материал	128,212,605.69	130,727,236.59
35410	Бичиг хэргийн материал	509,600.00	59,000.00
35420	Аж ахуйн материал	127,703,005.69	130,668,236.59
35600	Мал амьтад	9,757,000.00	7,120,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	783,965,486.80	815,636,197.01
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	783,965,486.80	815,636,197.01
392	Биет хөрөнгө	457,900,486.84	388,616,197.09
39201	Барилга, байгууламж, орон сууц	195,780,273.12	195,780,273.12
39202	Хуримтлагдсан элэгдэл	-27,835,758.46	-46,355,716.30
39203	Авто-тээврийн хэрэгсэл	236,368,939.98	236,368,939.98
39204	Хуримтлагдсан элэгдэл	-154,907,093.10	-198,208,641.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	124,023,551.64	140,297,951.64
39206	Хуримтлагдсан элэгдэл	-61,518,492.55	-79,530,355.23
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	25,060,922.88	25,060,922.88
39208	Хуримтлагдсан элэгдэл	-15,783,520.73	-17,326,196.88
39209	Зам, гүүрийн байгууламж	151,023,808.40	151,023,808.40
39210	Хуримтлагдсан элэгдэл	-14,312,144.34	-18,494,789.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,608,400.00	4,608,400.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-4,608,400.00	-4,608,400.00
393	Биет бус хөрөнгө	326,064,999.96	427,019,999.92
39301	Програм хангамж	7,100,000.00	7,100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,695,000.04	-5,260,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	322,660,000.00	425,180,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	948,193,056.49	972,541,397.60
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,025,964.00	15,025,964.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,025,964.00	15,025,964.00
413	Өглөг	15,025,964.00	15,025,964.00
4136	Бусад өглөг	15,025,964.00	15,025,964.00
41361	Байгууллагад төлөх өглөг	15,025,964.00	15,025,964.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	933,167,092.49	957,515,433.60
51	Засгийн газрын хувь оролцоо	933,167,092.49	957,515,433.60
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	963,806,089.24	1,066,326,089.24
51101	Өмч: - төрийн	963,806,089.24	1,066,326,089.24
512	Хуримтлагдсан үр дүн	-223,192,243.52	-301,363,902.41
51210	Өмнөх үеийн үр дүн	-431,587,168.78	-223,192,243.52
51220	Тайлант үеийн үр дүн	208,394,925.26	-78,171,658.89
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	192,553,246.77	192,553,246.77
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	948,193,056.49	972,541,397.60

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	191,922,178.75	446,139,118.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	341,178.75	70,618,518.00

120	Нийтлэг татварын бус орлого	341,178.75	70,618,518.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	341,178.75	70,618,518.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	341,178.75	70,618,518.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	191,581,000.00	375,520,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	190,747,000.00	346,415,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,747,000.00	346,415,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	834,000.00	29,105,600.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	834,000.00	21,965,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	140,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	179,176,566.73	489,192,816.89
21	УРСГАЛ ЗАРДАЛ	179,176,566.73	489,192,816.89
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	178,287,456.73	447,180,072.66
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,818,727.00	250,127,015.11
210101	Үндсэн цалин	93,720,771.00	187,334,934.11
210102	Нэмэгдэл	24,349,156.00	41,725,218.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,746,600.00	6,666,455.00
210104	Урамшуулал	00.00	14,200,408.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,677,584.69	31,523,665.56
210201	Тэтгэврийн даатгал	11,789,277.69	21,496,073.96
210202	Тэтгэмжийн даатгал	1,240,977.00	2,528,947.90
210203	ҮОМШЕ-ний даатгал	972,621.00	1,999,638.27
210204	Ажилгүйдлийн даатгал	243,157.00	499,909.63
210205	Эрүүл мэндийн даатгал	2,431,552.00	4,999,095.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,377,501.97	13,790,754.30
210301	Гэрэл, цахилгаан	1,520,089.37	2,562,062.21
210302	Түлш, халаалт	5,857,412.60	11,151,400.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	77,292.09
2104	Хангамж, бараа материалын зардал	5,488,877.50	17,384,995.90
210401	Бичиг хэрэг	656,900.00	1,308,000.00
210402	Тээвэр, шатахуун	3,241,660.00	9,824,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	760,237.50	1,319,002.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	25,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	830,080.00	955,208.00
210408	Бараа материал акталсны зардал	00.00	3,952,645.10
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	232,500.00	330,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	114,700.00
210604	Урсгал засвар	232,500.00	216,000.00
2107	Томилолт, зочны зардал	1,090,000.00	7,935,360.00
210702	Дотоод албан томилолт	1,090,000.00	7,935,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,449,892.00	30,371,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	20,390,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	835,800.00	801,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	269,612.00	374,698.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	121,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	7,200,000.00
210807	Газрын төлбөр	645,480.00	764,280.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,152,373.57	95,715,903.79
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,938,500.00	8,592,214.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,213,873.57	87,123,689.79
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	889,110.00	42,012,744.23

2132	Бусад урсгал шилжүүлэг	889,110.00	21,638,897.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,349,597.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	889,110.00	1,289,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	20,373,847.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	20,373,847.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	12,745,612.02	-43,053,698.89
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	35,117,960.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	35,117,960.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-35,117,960.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	12,745,612.02	-78,171,658.89

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /					
Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-410,266,264.66	617,272,167.23
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	856,306,089.24	171,232,342.65	-431,587,168.78	595,951,263.11
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	208,394,925.26	208,394,925.26
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	963,806,089.24	192,553,246.77	-223,192,243.52	933,167,092.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	963,806,089.24	192,553,246.77	-223,192,243.52	933,167,092.49
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-78,171,658.89	-78,171,658.89
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,066,326,089.24	192,553,246.77	-301,363,902.41	957,515,433.60

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	210,319,714.00	399,326,024.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	210,319,714.00	399,326,024.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	190,747,000.00	346,415,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	190,747,000.00	346,415,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	19,572,714.00	52,911,024.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	834,000.00	21,965,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	7,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,738,714.00	23,945,424.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	155,107,205.16	399,326,024.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	155,107,205.16	399,326,024.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	154,841,905.16	342,287,315.77
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	121,818,730.00	250,127,015.11
210101	Үндсэн цалин	93,720,774.00	187,380,510.54
210102	Нэмэгдэл	24,349,156.00	41,710,045.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,748,800.00	6,836,051.57
210104	Урамшуулал	00.00	14,200,408.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,677,581.69	31,523,665.56

Хүнс хөдөө аж ахуйн газарийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210201	Тэтгэврийн даатгал	11,789,276.09	21,496,073.96
210202	Тэтгэмжийн даатгал	1,240,976.40	2,528,947.90
210203	ҮОМШӨ-ний даатгал	972,621.13	1,999,638.27
210204	Ажилгүйдлийн даатгал	243,155.27	499,909.63
210205	Эрүүл мэндийн даатгал	2,431,552.80	4,999,095.80
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,377,501.97	13,790,754.30
210301	Гэрэл, цахилгаан	1,520,089.37	2,562,062.21
210302	Түлш, халаалт	5,857,412.60	11,151,400.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	77,292.09
2104	Хангамж, бараа материалын зардал	4,105,499.50	12,210,642.80
210401	Бичиг хэрэг	432,800.00	857,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,844,200.00	9,664,640.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	719,999.50	1,319,002.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	00.00	25,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	108,500.00	344,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	34,000.00	402,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	202,700.00
210604	Урсгал засвар	34,000.00	199,500.00
2107	Томилолт, зочны зардал	1,328,500.00	7,935,360.00
210702	Дотоод албан томилолт	1,328,500.00	7,935,360.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,449,892.00	23,171,678.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	20,390,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	600,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	835,800.00	801,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	269,612.00	374,698.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	99,000.00	121,000.00
210807	Газрын төлбөр	645,480.00	764,280.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,050,200.00	3,126,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,050,200.00	3,126,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,300.00	57,038,708.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	265,300.00	21,638,897.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	20,349,597.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	265,300.00	1,289,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	35,399,811.23
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	35,399,811.23
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/ төгрөгөөр /					
Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДУН	346,415,000.0	334,820,612.8	11,594,387.2	96.7

21	УРСГАЛ ЗАРДАЛ	346,415,000.0	334,820,612.8	11,594,387.2	96.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	324,776,100.0	313,181,715.8	11,594,384.2	96.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	260,517,400.0	250,127,015.1	10,390,384.9	96.0
210101	Үндсэн цалин	194,883,600.0	187,380,510.5	7,503,089.5	96.1
210102	Нэмэгдэл	42,182,900.0	41,710,045.0	472,855.0	98.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,497,700.0	6,836,051.6	661,648.4	91.2
210104	Урамшуулал	15,953,200.0	14,200,408.0	1,752,792.0	89.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	32,564,700.0	31,523,665.6	1,041,034.4	96.8
210201	Тэтгэврийн даатгал	22,144,000.0	21,496,074.0	647,926.0	97.1
210202	Тэтгэмжийн даатгал	2,605,200.0	2,528,947.9	76,252.1	97.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,084,100.0	1,999,638.3	84,461.7	95.9
210204	Ажилгүйдлийн даатгал	521,000.0	499,909.6	21,090.4	96.0
210205	Эрүүл мэндийн даатгал	5,210,400.0	4,999,095.8	211,304.2	95.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,952,700.0	13,790,754.3	161,945.7	98.8
210301	Гэрэл, цахилгаан	2,724,000.0	2,562,062.2	161,937.8	94.1
210302	Түлш, халаалт	11,151,400.0	11,151,400.0	00.0	100.0
210303	Цэвэр, бохир ус	77,300.0	77,292.1	07.9	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	6,796,400.0	6,795,402.8	997.2	100.0
210401	Бичиг хэрэг	662,300.0	662,300.0	00.0	100.0
210402	Тээвэр, шатахуун	4,444,500.0	4,444,500.0	00.0	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,320,000.0	1,319,002.8	997.2	99.9
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	25,500.0	25,500.0	00.0	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	344,100.0	344,100.0	00.0	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	402,200.0	402,200.0	00.0	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	202,700.0	202,700.0	00.0	100.0
210604	Урсгал засвар	199,500.0	199,500.0	00.0	100.0
2107	Томилолт, зочны зардал	1,535,600.0	1,535,600.0	00.0	100.0
210702	Дотоод албан томилолт	1,535,600.0	1,535,600.0	00.0	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,881,100.0	5,881,078.0	22.0	100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,100,000.0	3,100,000.0	00.0	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.0	720,000.0	00.0	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	801,100.0	801,100.0	00.0	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	374,700.0	374,698.0	02.0	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	121,000.0	121,000.0	00.0	100.0
210807	Газрын төлбөр	764,300.0	764,280.0	20.0	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,000.0	3,126,000.0	00.0	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,126,000.0	3,126,000.0	00.0	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,638,900.0	21,638,897.0	03.0	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	21,638,900.0	21,638,897.0	03.0	100.0
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,349,600.0	20,349,597.0	03.0	100.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,289,300.0	1,289,300.0	00.0	100.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	346,415,000.0	334,820,612.8	11,594,387.2	96.7
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	346,415,000.0	334,820,612.8	11,594,387.2	96.7
132001	Орон нутгийн төсвөөс	346,415,000.0	334,820,612.8	11,594,387.2	96.7
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	23.00	22.00	01.00	95.7
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	00.00	100.0
610002	Төсвөөс гадуур байгууллага	01.00	01.00	00.00	100.0
620001	Удирдах ажилтан	22.00	21.00	01.00	95.5
620002	Гүйцэтгэх ажилтан	01.00	01.00	00.00	100.0
620003	Үйлчлэх ажилтан	13.00	12.00	01.00	92.3
620004	Гэрээт ажилтан	08.00	08.00	00.00	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл / төгрөгөөр /
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	29,105,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	29,105,600.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	29,105,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	5,415,240.00
210401	Бичиг хэрэг	195,100.00
210402	Тээвэр, шатахуун	5,220,140.00
2107	Томилолт, зочны зардал	6,399,760.00
210702	Дотоод албан томилолт	6,399,760.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,290,600.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	17,290,600.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	23,805,424.00
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	23,805,424.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	52,911,024.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	52,911,024.00
131103	ЗГНХ,ЗДНХерөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	21,965,600.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	23,945,424.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00

3. Аудитын тайлан

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Хүнс хөдөө аж ахуйн газар нь Хүнс, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж буй Засгийн газрын бодлого, шийдвэр эрх зүйн хэм хэмжээг сурталчлан таниулах, хэрэгжилтийг ханган ажиллуулахын зэрэгцээ эдийн засгийн тогтвортой хөгжил, тэдгээрийн үр ашгийг дээшлүүлж, иргэдийг эрүүл, чанартай хүнсээр хүртээмжтэй хангахад чиглэх гэсэн эрхэм зорилго тавин ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад дотоод орчин

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Хүнс хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны 2021 оны А/63 дугаар тушаалаар батлагдсан байгууллагын бүтцэд хяналт шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хариуцсан ажилтныг

томилсон ба ба дотоод аудитын төлөвлөгөөг батлуулж, төлөвлөгөө бүрд ажлын удирдамж гарган батлуулж, хэрэгжилтийг тооцон ажилласан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хүнс хөдөө аж ахуйн газарийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж тайлагнасан байна.

Тус байгууллага нь ХХААХҮ-ийн яамны сайдын тушаалаар батлагдсан “Хүнс хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод материаллаг хэмжээний өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,384.3 мянган төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мянган төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	19,057.96	19,057.96	00.00
Бараа материал	137,969.61	137,847.24	-122.4
Биет хөрөнгө	457,900.49	388,616.20	-69,284.3
Биет бус хөрөнгө	326,065.00	427,020.00	100,955.0
Нийт хөрөнгө	948,193.06	972,541.40	24,348.3
Дансны өглөг	15,025.96	15,025.96	00.00
Хуримтлагдсан үр дүн	-223,192.24	-301,363.90	-78,171.7
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	948,193.06	972,541.40	24,348.3

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, авлага үндсэн хөрөнгө, бараа материал, өр төлбөр гэсэн данс тус бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна. Тайлант онд үндсэн хөрөнгө, бараа материал дансанд дараах хөдөлгөөн хийгдсэн байна. Үүнд:

- ХХААХҮЯ-аас 16,274.4 мянган төгрөгийн өртөгтэй компьютер, принтерийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.
- Бүрэнтогтох сумын Засаг даргын А/76 дугаар тоот тушаалаар 5001м.кв 100,020.0 мянган төгрөгийн газрыг, Аймгийн Засаг даргын №А/187 дугаар тоот захирамжаар 100 м.кв хэмжээтэй 2,500.0 мянган төгрөгийн газрын зөрүүг нэмж бүртгэсэн байна.
- ХХААХҮЯ-аас 43,897.4 мянган төгрөгийн хүнсний ногооны үрийг үнэ төлбөргүй хүлээн авч ХХААХҮЯ-ны сайдын 2022-04-12-ны А/120 тушаалаар “Хүнсний ногоо”

хөтөлбөрийн хүрээнд улсын төсвийн хөрөнгөөр худалдан авсан хүнсний ногооны урийн үнийг 80 хувийн хөнгөлттэй үнээр зарсан байна.

Нэмэлт санхүүжилтийн данснаас төвлөрүүлсэн 15,025.9 мянган төгрөг болон Гэрээт малчин гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас малын дутагдал гарч хувь хүмүүсээс авах авлага үүссэний 4,032.0 мянган төгрөг, нийт 19,057.9 мянган төгрөгийн авлагын үлдэгдэлтэй байна.

Хуримтлагдсан үр дүн данс 78,171.7 мянган төгрөгөөр буурсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд 2,593,769.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, тооцон төлөвлөж 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн 1/328 тоот албан бичгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 2,271,559.4 мянган төгрөгөөр бууруулж, 322,210.2 мянган төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Төсвийн төслөөс конторын барилга барих 1,800,000.0 мянган төгрөг, урсгал засвар хийх 243,000.0 мянган төгрөгийг тус тус хасаж баталсан байна. Төсөвт 24,204.8 мянган төгрөгөөр тодотгол хийж, 346,415.0 мянган төгрөгөөр батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн 3 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 346,415.0 мянган төгрөгийн төсөв баталж улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлжээ.

Гүйцэтгэлээр 334,820.6 мянган төгрөгийг урсгал үйл ажиллагааны зардалд зарцуулж, 11,594.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 1. Хөтөлбөр, арга хэмжээний зардал

/мянган төгрөгөөр/

Хөтөлбөр, арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
70802	Газар тариалан хөгжүүлэх	1,500.0	1,500.0	0.0	100.0
80101	Үндсэн үйл ажиллагаа	1,500.0	1,500.0	0.0	100.0
70805	Хөдөө аж ахуй, газар тариалангийн бодлого	343,315.0	331,720.6	11,594.4	91.6
80101	Үндсэн үйл ажиллагаа	321,676.1	310,081.7	11,594.4	100.0
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж	21,638.9	21,638.9	0.0	100.0
72101	Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих	1,600.0	1,600.0	0.0	100.0
80101	Үндсэн үйл ажиллагаа	1,600.0	1,600.0	0.0	100.0
	НИЙТ	346,415.0	334,820.6	11,594.4	96.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд :

- 2021 онд нэмэлт санхүүжилтийн данснаас татан төвлөрүүлсэн 15,025.9 мянган төгрөг
- Сумдад олгосон үр тарианы үнэ 8,779.4 мянган төгрөг
- Аймгийн Засаг даргаас Шинэ хөдөө – Хөвсгөл төслийн малчны цалин, НДШ-д 13,500.0 мянган төгрөг, цөм сүргийн өвс тэжээл хүргэх зардалд 1,690.6 мянган төгрөг, "Намрын ногоон өдрүүд-Үндэсний үйлдвэрлэл 2022" нэгдсэн арга хэмжээнд оролцох үйл ажиллагааны санхүүжилт 5,252.0 мянган төгрөг, хоршоог хөгжүүлэх, үнэлэх ажилд 1,523.0 мянган төгрөг
- Жижиг дунд үйлдвэрийн газраас Хоршооны хөгжлийг дэмжих жил аяны хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний зардалд 3,000.0 мянган төгрөг
- Хүнс хөдөө аж ахуйн биржээс мэдээлэл судалгааны ажлын төлбөрт 4,000.0 мянган төгрөгийн орлого нийт 52,911.0 мянган төгрөгийн орлого орсон байна.

Нэмэлт санхүүжилтийн зардлыг тухай бүрт нь зохих журмын дагуу эрх нээлгэж зарцуулсан ба зарцуулаагүй үлдэгдэл 23,805.4 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Хүнс хөдөө аж ахуйн газарийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ийн захирал Х.Диймаа, аудитор Н.Бадамханд нар гүйцэтгэж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Ичинхорлоо, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд чанарын хяналтыг хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Хаан соёмбо аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 1/76 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр төсвийн гүйцэтгэлийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 529,467.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 10,589.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 буюу 8,471.5 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага Тэргүүн дэд, дэд, орлогч дарга, тээврийн хэрэгсэл, албан тасалгаа, дүрэмт хувцас, албан томилот, нэг удаагийн мөнгөн тэтгэмж, бусад хангамж, цахим худалдан авалт, Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд хориглосон зарим асуудал, Төсвийн

байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн авч хэрэгжүүлэх арга хэмжээний нийт 29 асуудлаар хяналтыг хэрэгжүүлэхэд дараах зөрчилтэй зүйл илэрлээ.

Илрүүлэлт:

Байгууллагын хөрөнгөөр 447.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5 “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Байгууллагын 2022 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрийг pdf хэлбэрээр мэдээлээгүй байгаа нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар мэдээлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь 2022 онд зохион байгуулсан худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэхгүй байгаа тул зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Хүнс хөдөө аж ахуйн газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийж, балансын дансдууд нь тодруулгатай таарахгүй байсан алдааг залруулах зөвлөмж хүргүүлж хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хүнс хөдөө аж ахуйн газарийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар мэдээллийн тл тод байдал болон мэдээлэл авах эрхийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хүргүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Зөвлөмж	2	0.0	2	0.0	100
Нийт дүн	2	0.0	2	0.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар онцгойлон үзэх асуудал байхгүй байна.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 447.0 мянган төгрөгийн зөрчил илэрч 1 төлбөрийн акт тогтоож, 1 зөвлөмжийг хүргүүлж байна.

5.2 Төлбөрийн акт

Байгууллагын хөрөнгөөр 447.0 мянган төгрөгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.5 “төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах” гэсэн заалттай нийцэхгүй байгаа тул төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэлээ.

5.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой

1.1. Илрүүлэлт:

Төсөв хөрөнгө зарцуулахтай холбоотой гарсан шийдвэрийг pdf хэлбэрээр мэдээлээгүй байгаа нь Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.2.11. зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл болон төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд байгуулсан гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулсан, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг гарсан өдрөөс хойш 7 хоногийн дотор энэ журмын 10 дугаар хавсралтад заасан маягтын дагуу PDF форматаар мэдээлнэ гэсэн заалттай нийцэхгүй байна.

1.2. Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хөрөнгө зарцуулсан шийдвэрийг журамд заасны иж бүрэн мэдээлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 01 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажигтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/ Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төрийн хэмнэлтийн тухай	1	447.0	1	447.0								

Хүнс хөдөө аж ахуйн газарийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

хуулийн хэрэгжилттэй холбоотой											
Дүн	1	447.0	1	447.0							

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/					
			Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Тоо	Дүн
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Өмч хөрөнгө зарцуулах шийдвэрийг мэдээлээгүй.	1	0.0					1	0.0
Нийт дүн	1	0.0					1	0.0

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

ХААН СОЁМБО АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ

АУДИТОР

АУДИТЫН ТАЙЛАНГ:



А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:



Х.ДИЙМАА

Н.БАДАМХАНД